



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 5/33

Ховд

Б.Баярсайханыг Цэцэг сумын  
Засаг даргаар томилох тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 56.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1 дэх заалт, Цэцэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 05/19037 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Батмөнхийн Баярсайханыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн Цэцэг сумын Засаг даргаар томилсугай.

2. Б.Баярсайханыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралтаар баталсан "Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ"-ний зохих шатлалаар цалинжуулж, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцон холбогдох бусад нэмэгдлийг сар бүр бодож олгохыг Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (М.Солонго)-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай бүрд тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Б.Баярсайханд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА